



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/14

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрөөс санхүүжигдэх “Эрдмийн Өргөө” цогцолбор сургуулийн засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаартай зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Булган аймгийн “Булган барилга” ХХК-тай 229 235 894 /Хоёр зуун хорин есөн сая хоёр зуун гучин таван мянга найман зуун ерэн дөрөв/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хүлээн авахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Булган барилга” ХХК /С.Сэр-Од/-д үүрэг болгосугай.



З.БАТЗОРИГ

20200037